

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС, БҮГД  
НАЙРАМДАХ КУБА УЛСЫН ХООРОНД ИРГЭН, ГЭР БҮЛ  
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА  
ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

/1988.10.29/

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Куба Улс тус хоёр орны ард түмний ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэн хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлийн удирдлага болгон,

эрх зүйн салбар дахь хамтын ажиллагаа боловсронгуй болгож,

хоёр орны иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Гэрээ байгуулахаар шийдвэрлэж энэ зорилгоор өөрийн бүрэн эрхт төлөөлөгчөөр Бүгд Найрамдах Монгол Ардын Их Хурлын Тэргүүлэгчид Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Хууль зүй, арбитрайн яамны орлогч сайд Осорын АМАРХҮҮ,

Бүгд Найрамдах Куба Улсын Төрийн Зөвлөл Бүгд Найрамдах Куба Улсаас БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт сайд Альсидес де ла Роса дель Торо

нарыг тус тус томилсонд тэд зохих хэлбэр, журамд зохицсон бүрэн эрхийнхээ үнэмлэхийг солилцоод дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов.

**I ХЭСЭГ**

**Нийтлэг заалт**

**1 дүгээр зүйл**

**Эрх зүйн хамгаалалт**

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд болон хуулийн этгээд (цаашид “иргэд” гэж нэрлэх) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байхдаа хувийн болон эд хөрөнгийн эрхийн хувьд тухайн улсын иргэн болон хуулийн этгээдийн нэгэн адил эрх зүйн хамгаалалт эдэлнэ.
2. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд нөгөө Талын шүүх, прокурор, улсын нотариатын байгууллагад (цаашид “хуулийн байгууллага” гэж нэрлэх) болон иргэн, хөдөлмөр, гэр бүл, эрүүгийн хэрэг авч хэлэлцэх эрх бүхий бусад байгууллагад чөлөөтэй, саадгүй хандах, хүсэлт тавих, нэхэмжлэл гаргах, гомдол мэдүүлэх болон байцаан шийтгэх ажиллагааны бусад үйлдэл хийх эрхийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний нэгэн адил эдэлнэ.

**2 дугаар зүйл**

**Эрх зүйн туслалцаа үзүүлэх**

1. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хуулийн байгууллагууд нь иргэн (хөдөлмөрийнхийг оролцуулаад), гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааг харилцан үзүүлнэ.
2. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хуулийн байгууллагууд нь энэ зүйлийн 1-д заасан асуудлыг авч хэлэлцэх эрх бүхий бусад байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлнэ.

### **3 дугаар зүйл Харилцах журам**

Энэ Гэрээнд өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын хуулийн байгууллага эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ тус тусын төв байгууллагаар дамжуулан харилцаж байна.

### **4 дүгээр зүйл Эрх зүйн туслалцааны хэлбэр**

Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хүсэлтээ бие дааж шууд гаргасан, түүнчлэн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, эсхүл энэ Гэрээний III хэсэгт заасны дагуу шүүхийн шийдвэрийг биелүүлж байгаагаас бусад тохиолдолд Гэрээний дагуу үзүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлт нь ямагт даалгаврын хэлбэртэй байна.

### **5 дугаар зүйл Эрх зүйн туслалцааны хэмжээ**

Хэлэлцэн тохирогч Талууд бичиг баримт хүргүүлэх, гардуулан өгөх, хууль тогтоомж болон шүүхийн практикийн асуудлаар мэдээлэл солилцох, байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах, тухайлбал, нэгжлэг хийх, эд мөрийн баримт хүргүүлэх буюу шилжүүлэн өгөх, ялтан, шүүгдэгч, яллагдагчийг байцаах, гэрч, шинжээч, зохигчдыг асуух замаар харилцан эрх зүйн туслалцаа үзүүлнэ.

### **6 дугаар зүйл Даалгаврын агуулга**

Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт дор дурдсан зүйлийг тусгасан байна:

1. Даалгавар өгсөн хуулийн байгууллагын нэр;
2. Даалгавар хүлээн авах хуулийн байгууллагын нэр;
3. Эрх зүйн туслалцаа авахаар хүсэлт тавигдаж байгаа хэргийн нэр;
4. Зохигчид, яллагдагч, шүүгдэгч, гэрч болон хэргийн бусад оролцогчдын овог, нэр, тэдний оршин суугаа газар, гэр бүлийн байдал, иргэний харьяалал, мэргэжил, эрхэлж буй ажил;
5. Зохигчдын төлөөлөгчдийн овог, нэр, хаяг;
6. Эрүүгийн хэргийн талаархи даалгаварт дээрхээс гадна үйлдсэн гэмт хэргийн бодит нөхцөл байдал, хуулийн зүйл анги, түүнчлэн яллагдагч буюу ялтны овог нэр, хаяг, байгаа буюу түр оршин суугаа газар, иргэний харьяалал, гэр бүлийн байдал, мэргэжил, эрхэлж буй ажил, эцэг эхийн нэр, мөн боломжтой бол яллагдагч буюу ялтны төрсөн газар, он, сар, өдрийг заана.

### **7 дугаар зүйл Даалгавар биелүүлэх журам**

1. Даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага нь даалгаврыг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ. Хэрэв өөрийн улсын хууль тогтоомжид харшлахгүй бол даалгавар өгсөн хуулийн байгууллагын хүсэлтээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хууль тогтоомжид заасан байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг хэрэглэж болно.
2. Хэрэв даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага уг даалгаврыг биелүүлэх эрхгүй байвал түүнийг эрх бүхий байгууллагад шилжүүлэн өгч, энэ тухайгаа даалгавар өгсөн хуулийн байгууллагад мэдэгдэнэ.
3. Хэрэв холбогдох иргэн даалгаварт заасан хаягаар оршин суудаггүй байвал даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага түүний оршин суугаа газрыг тогтоох талаар бололцоотой арга хэмжээг авна.
4. Даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага нь түүнийг биелүүлсний дараа даалгаварт хавсаргасан бичиг баримтыг даалгавар өгсөн байгууллагад буцааж хүргүүлнэ. Хэрэв даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага уг даалгаврыг биелүүлж чадаагүй бол бичиг баримтыг даалгавар өгсөн байгууллагад буцаахын зэрэгцээ даалгавар биелүүлэхэд саад болж байгаа шалтгааныг түүнд мэдэгдэнэ.

### **8 дугаар зүйл Бичиг баримтыг гардуулсныг нотлох**

Даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага нь бичиг баримтыг гардуулснаа өөрийн улсад дагаж мөрддөг журмын дагуу нотолно. Уг нотолгоонд бичиг баримтыг гардуулсан он, сар, өдөр, хүлээн авсан, гардуулж өгсөн хүний гарын үсэг, шүүхийн тамга, эсхүл гардуулсныг нотолсон хуулийн байгууллагын нотолгоог заах ёстой.

**9 дүгээр зүйл**  
**Дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын эрх хэмжээ**

Хэлэлцэн тохирогч аль ч Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газраар дамжуулан өөрийн иргэдэд бичиг баримт гардуулан өгч болно.

**10 дугаар зүйл**  
**Эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардал**

1. Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдож нутаг дэвсгэрт гарсан зардлыг хариуцна.
2. Даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага нь даалгавар өгсөн байгууллагад гарсан зардлын хэмжээг мэдэгдэж байна. Хэрэв даалгавар өгсөн байгууллага нь уг зардлыг төлөх үүрэг бүхий этгээдээс хураан авсан бол тэр нь зардлыг гаргуулж авсан Хэлэлцэн тохирогч Талын орлого болно.

**11 дүгээр зүйл**  
**Бичиг баримтын нотлох чадвар**

Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллага тогтоосон хэлбэрийн дагуу үйлдсэн буюу гэрчилсэн бөгөөд тамга дарсан бичиг баримт буюу албан ёсоор батлагдсан орчуулга нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ямар нэгэн өөр баталгаагүйгээр нотлох чадвартай байна. Энэ нь зохих Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт дагаж мөрдөж байгаа журмын дагуу гарын үсэг нь батлагдсан иргэдийн бичиг баримтад нэгэн адил хамаарна.

**12 дугаар зүйл**  
**Гэрч, шинжээчийг дуудах**

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт оршин суугаа этгээдийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гэрч буюу шинжээчээр байцаах шаардлага гарвал дуудлагыг Хэлэлцэн тохирогч тэр Талын эрх бүхий байгууллагаар дамжуулан гардуулна.
2. Дуудагдаж буй этгээд ирэхгүй бол хүлээлгэх хариуцлагын тухай зарлан дуудах хуудсанд сануулж бичихгүй.
3. Гэрч буюу шинжээчид төлөх зардал, олгох шагналын хэмжээг зарлан дуудах хуудас гардуулах тухай даалгаварт заасан байна.

**13 дугаар зүйл**  
**Гэрч, шинжээч нарын халдашгүй эрх**

1. Дуудлага аваад Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад сайн дураараа очсон гэрч буюу шинжээчийг тэд аль улсын харьяат болохыг үл харгалзан даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хилийг нэвтрэн орохоос өмнө үйлдсэн эрх зүйн зөрчилд холбогдуулан эрүүгийн буюу захиргааны хариуцлага хүлээлгэж, баривчилж, эсхүл шийтгэж, мөн урьд өмнө гаргасан таслан шийдвэрлэх тогтоолоор ял шийтгэл хүлээлгэж болохгүй.
2. Гэрч буюу шинжээч нь байцаалт явуулсан хуулийн байгууллагаас тэд цаашид байх шаардлагагүй гэж мэдэгдсэнээс хойш бололцоо байсаар атал 15 өдрийн дотор тухайн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс гарч яваагүй бол энэ зүйлийн 1-д заасан баталгааг алдана. Гэрч буюу шинжээч өөрсдөөс нь үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс гарч чадаагүй саатсан хугацааг дээрх хугацаанд оруулан тооцохгүй.

**14 дүгээр зүйл**  
**Хувийн байдлын тухай бичиг баримт солилцох**

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр нөгөө Талын иргэдийн эрх, ашиг сонирхолд хамаарах иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн актаас авсан хуулбар, боловсрол, ажилласан хугацааны тухай болон бусад бичиг баримтыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талд түүний хүсэлтээр илгээж байна.
2. Энэ зүйлийн 1-д заасан бичиг баримтыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт орчуулгагүй, үнэ төлбөргүй илгээнэ.

**15 дугаар зүйл**  
**Хууль тогтоомжийн тухай мэдээлэл солилцох**

Хэлэлцэн тохирогч Талуудын Шүүх яамд, БНМАУ-ын Прокурорын газар, БНКУ-ын Ерөнхий Прокурорын газар нь зохих хууль тогтоомжийн талаар мэдээлэл солилцож байна.

**16 дугаар зүйл**  
**Харилцах хэл**

1. Хэлэлцэн тохирогч Талуудын шүүхүүд болон эрх бүхий бусад байгууллагууд хооронд харилцахдаа өөрийн улсын албан ёсны хэл, эсхүл орос хэлийг хэрэглэнэ.
2. Эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааг хөнгөвчлөхийн тулд энэхүү Гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд ч бичиг баримтыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хэлээр, эсхүл орос хэлээр аль болох орчуулан хавсаргаж байна.

**II ХЭСЭГ**  
**Иргэний болон гэр бүлийн хэргийн талаар**  
**эрх зүйн туслалцаа үзүүлэх**

**Нэгдүгээр бүлэг**  
**Хувийн горим**

**17 дугаар зүйл**  
**Эрхийн болон эрх олох, үүрэг бий болгох чадвар**

1. Иргэний эрхийн болон эрх олох, үүрэг бий болгох чадварыг уг иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.
2. Хуулийн этгээдийн эрхийн болон эрх олох, үүрэг бий болгох чадварыг түүний оршин байгаа газрын Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.
3. Өдөр тутмын хэрэгцээг хангахад чиглэсэн ахуйн жижиг хэлцэл хийхэд иргэний эрхийн болон эрх олох, үүрэг бий болгох чадварыг нутаг дэвсгэр дээр нь уг хэлцлийг хийж байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

**18 дугаар зүйл**  
**Эрх олох, үүрэг бий болгох чадварыг хасах буюу хязгаарлах**

1. Иргэний эрх олох, үүрэг бий болгох чадварыг хасах, хязгаарлах асуудлыг уг иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэн шийдвэрлэх эрх бүхий байна.
2. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллага нутаг дэвсгэртээ байнга буюу түр оршин суугаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний эрх олох, үүрэг бий болгох чадварыг хасах буюу хязгаарлах шалтгаантай гэж үзвэл энэ тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт мэдэгдэж, шаардлагатай бол уг этгээдийг болон түүний эд хөрөнгийг хамгаалах талаар зохих арга хэмжээ авна.
3. Хэрэв эрх олох, үүрэг бий болгох чадварыг хасах, хязгаарлах ажиллагааг тухайн иргэнийг харьяалах Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага зургаан сарын дотор эхлэхгүй буюу энэ талаар хариу өгөхгүй бол Хэлэлцэн тохирогч нөгөө Тал Хэлэлцэн тохирогч хоёр талын хууль тогтоомжийг баримтлан уг ажиллагааг гүйцэтгэж энэ тухай шийдвэрээ Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад явуулна.

**19 дүгээр зүйл**  
**Сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох**

1. Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоох тухай хэргийг сүүлчийн мэдээ баримтаар уг иргэн амьд ахуй цагтаа харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна.
2. Хэлэлцэн тохирогч нэг Талын хуулийн байгууллага нь өөрийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа бөгөөд эрх, ашиг сонирхол нь энэхүү Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид үндэслэсэн сонирхогч этгээдийн хүсэлтээр Хэлэлцэн Тохирогч нөгөө Талын иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцож, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоож болно.
3. Энэ зүйлийн 2-т заасны дагуу иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоохдоо сураггүй алга болсон буюу нас барсан иргэн харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын, эсхүл шүүх нь шийдвэр гаргах ёстой Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

**Хоёрдугаар бүлэг  
Гэр бүлийн хэрэг**

**20 дугаар зүйл  
Гэрлэх**

1. Гэрлэх нөхцөлийг гэрлэхийг хүсэгч бүр дээр тэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Тал тус бүрийн хууль тогтоомжоор тодорхойлно.
2. Гэрлэлт бүртгэх хэлбэрийг нутаг дэвсгэрт нь гэрлэлтийг бүртгэж байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

**21 дүгээр зүйл  
Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн  
эрхийн харилцаа**

1. Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааг тэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.
2. Хэрэв гэрлэгсдийн аль нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суудаг бөгөөд хоёул ижил харьяалалтай бол тэдний хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааг тэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.
3. Хэрэв гэрлэгсдийн аль нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын харьяат, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын харьяат бол тэдний хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааг тэд хамгийн сүүлд хамт оршин сууж байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.
4. Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааны асуудлыг өмнөх зүйлүүдэд заасны дагуу хууль тогтоомжийг нь хэрэглэх Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Хэрэв гэрлэгсэд Хэлэлцэн тохирогч нэг талын харьяат бөгөөд хоёул Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа бол уг асуудлыг тэдний оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна.

**22 дугаар зүйл  
Гэрлэлтийг цуцлах**

1. Гэрлэснийг цуцлахдаа энэ тухай хэргийг үүсгэх үед гэрлэгсэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.
2. Хэрэв гэрлэгсэд гэрлэлтээ цуцлах хэргийг үүсгэх үедээ өөр өөр харьяалалтай байвал гэрлэснийг цуцлахдаа тэд хамгийн сүүлд хамт оршин сууж байгаа буюу оршин сууж байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

**23 дугаар зүйл  
Гэрлэснийг хүчингүйд тооцох**

Гэрлэснийг хүчингүйд тооцохдоо хууль тогтоомжийнх нь дагуу гэрлэсэн Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

**24 дүгээр зүйл  
Гэрлэлтийн тухай хэрэг шийдвэрлэх харьяалал**

Энэхүү Гэрээний 22, 23 дугаар зүйлд дурдсан асуудлыг гэрлэгсэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын шүүх, эсхүл гэрлэгсэд нутаг дэвсгэрт нь хамт оршин байгаа буюу хамгийн сүүлд хамт оршин сууж байсан Хэлэлцэн тохирогч Талын шүүх шийдвэрлэх эрх бүхий байна.

**25 дугаар зүйл  
Эцэг, эх, хүүхдийн эрхийн харилцаа**

1. Хүүхдийн эцгийг тогтоох, хүлээн зөвшөөрөх, маргахтай болон хүүхэд уг гэр бүлээс төрснийг тогтоохтой холбогдсон бүх асуудлыг хүүхэд төрөөд харьяат нь болсон Хэлэлцэн Тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.
2. Бусад тохиолдолд эцэг эх, хүүхдийн харилцаанд хүүхэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг хэрэглэнэ.
3. Эдгээр асуудлыг хүүхэд харьяат нь байгаа, эсхүл уг хүүхэд нутаг дэвсгэрт нь оршин сууж байгаа Хэлэлцэн тохирогч Талын шүүх харьяалан шийдвэрлэнэ.

## **26 дугаар зүйл Үрчлэлт**

1. Хүүхэд үрчлэх, түүнийг хүчингүй болгохдоо хүүхдийг үрчлэх үед үрчлэн авагч харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.
2. Үрчлэгдэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын харьяат бол үрчлэн авахад түүний хууль ёсны төлөөлөгчийн болон төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг, хэрэв үрчлэгдэгч нь харьяат нь байгаа улсын хууль тогтоомжид заасан бол үрчлэгдэгчийн зөвшөөрлийг тус тус авна.
3. Хэрэв хүүхэд үрчлэн авч байгаа эхнэр, нөхөр хоёр нь өөр өөр харьяалалтай бол үрчлэх, түүнийг хүчингүй болгохдоо Хэлэлцэн тохиролцогч хоёр Талын хууль тогтоомжийг баримтална.
4. Үрчлэх, түүнийг хүчингүй болгохтой холбогдсон асуудлыг хүүхэд үрчлэх үед үрчлэн авагч харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрхлэн шийдвэрлэнэ. Энэ зүйлийн 3-т заасан тохиолдолд нутаг дэвсгэрт нь эхнэр, нөхөр хоёр хамт оршин сууж байгаа буюу хамгийн сүүлд хамт оршин сууж байсан Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байна.

### **Асран хамгаалах, харгалзан дэмжих**

## **27 дугаар зүйл**

### **Асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоох**

1. Асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоох, хүчингүй болгох асуудлыг асран хамгаалах, харгалзан дэмжих (цаашид “асруулагчид” гэж нэрлэнэ) шаардлагатай иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын зохих байгууллага өөрийн улсын хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэх эрх бүхий байна.
2. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон асруулагчийн эрхийн харилцааг байгууллага нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилсон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.
3. Асран хамгаалах, харгалзан дэмжих үүргийг хүлээн авах харилцаанд асран хамгаалагч, харгалзан дэмжигч харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг хэрэглэнэ.
4. Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа иргэний асран хамгаалагч буюу харгалзан дэмжигчээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг томилж болно. Гэхдээ уг иргэн асран хамгаалагч буюу харгалзан дэмжигчийн эрхийг хэрэгжүүлэх ёстой улсын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа бөгөөд түүнийг томилох нь асруулагчийн эрх ашигт нийцэж байгаа нөхцөлд үүнийг хэрэглэнэ.

## **28 дугаар зүйл**

### **Хамгаалах түр арга хэмжээ**

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга буюу түх оршин суугаа, эсхүл эд хөрөнгө нь байгаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэний эрх, ашиг сонирхлыг хамгаалах шаардлага гарвал тухайн Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага уг иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт энэ тухай нэн даруй мэдэгдэнэ.
2. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хуулийн байгууллага хойшлуулшгүй тохиолдолд өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу урьдчилан арга хэмжээ авч болох бөгөөд энэ тухайгаа энэ зүйлийн 1-д зааснаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт нэн даруй мэдэгдэнэ. Ийнхүү авсан арга хэмжээ нь эрх бүхий байгууллагаас өөр шийдвэр гаргах хүртэл хүчин төгөлдөр байна.

## **29 дүгээр зүйл**

### **Асран хамгаалалт, харгалзан дэмжлэгийг шилжүүлэх**

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт асруулагч байнга буюу түр оршин суугаа, эсхүл түүний эд хөрөнгө байгаа бол энэхүү Хэлэлцэн тохирогч Талын байгууллагад асран хамгаалалт буюу харгалзан дэмжлэгийг энэ Гэрээний 27 дугаар зүйлийн 1-д заасан журмыг баримтлан шилжүүлж болно. Асран хамгаалалт, харгалзан дэмжлэгийг шилжүүлсэн нь хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын байгууллага асран хамгаалах, харгалзан дэмжих явдлыг өөртөө хүлээн авснаа хүсэлт тавьсан Хэлэлцэн тохирогч Талын байгууллагад мэдэгдсэн үеэс хүчин төгөлдөр болно.
2. Энэ зүйлийн 1-д зааснаар асран хамгаалалт, харгалзан дэмжлэгийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын байгууллага уг асуудлыг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх боловч асруулагчийн хувийн эрх, үүрэгтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргах эрхгүй.

### **Гуравдугаар бүлэг Өв залгамжлал**

**30 дугаар зүйл**  
**Тэгш эрхийн зарчим**

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийг хууль ёсоор буюу гэрээслэлээр өвлөхөд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнтэй адил тэгш эрх эдэлнэ.
2. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа өөрийн эд хөрөнгийг гэрээслэлийн дагуу захиран зарцуулж болно.
3. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт өв залгамжлан авсан эд хөрөнгөө эрх зүйн хэлцлийн үндсэн дээр захиран зарцуулж болно.

**31 дүгээр зүйл**  
**Өв залгамжлах эрх**

1. Хөдлөх эд хөрөнгө өвлөа эрхийг өвлүүлэгч нас барах үедээ харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна
2. Үл хөдлөх эд хөрөнгө өвлөх эрхийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.
3. Ямар эд хөрөнгийг хөдлөх, үл хөдлөх гэж үзэхийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

**32 дугаар зүйл**  
**Өвлөгчгүй эд хөрөнгө**

Өвлөгчгүй үлдсэн хөдлөх эд хөрөнгө нь өвлүүлэгч нас барах үедээ харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын, үл хөдлөх хөрөнгө бол нутаг дэвсгэрт нь уг эд хөрөнгө байгаа Хэлэлцэн тохирогч Талын орлого болно.

**33 дугаар зүйл**  
**Гэрээслэл**

1. Гэрээслэл үйлдэх буюу хүчингүй болгох чадвар, түүнчлэн санаа зоригоо зохих ёсоор илэрхийлж чадаагүйн улмаас үүссэн маргааныг өвлүүлэгч санаа зоригоо илэрхийлэх үедээ харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.
2. Гэрээслэл үйлдэх, түүнийг хүчингүй болгох хэлбэрийг өвлүүлэгч гэрээслэл үйлдэх буюу түүнийг хүчингүй болгох үедээ харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно. Гэрээслэл үйлдэх, түүнийг хүчингүй болгох хэлбэр нь нутаг дэвсгэрт нь уг гэрээслэлийг үйлдсэн буюу хүчингүй болгосон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримталсан нөхцөлд хүчин төгөлдөр байна.

**34 дүгээр зүйл**  
**Эрх хэмжээний талаар**

1. Энэ зүйлийн 3-т зааснаас бусад тохиолдолд хөдлөх эд хөрөнгийг өв залгамжлахтай холбогдсон хэргийг өвлүүлэгч нас барах үедээ харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна.
2. Үл хөдлөх эд хөрөнгийг өв залгамжлахтай холбогдсон хэргийг уул эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна.
3. Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн нас барсны дараа түүний өвлөгдвөл зохих бүх хөдлөх эд хөрөнгө Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байвал эд хөрөнгө Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байвал өв залгамжлах тухай хэргийг өв залгамжлагчдын хэн нэгний нь хүсэлтээр, өв залгамжлах бусад хүмүүсийн зөвшөөрөлтэйгөөр өв хөрөнгө нь нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллага хэлэлцэнэ.
4. Өв залгамжлахтай холбогдож үүссэн маргааныг шийдвэрлэхэд энэ зүйлийн 1, 2, 3-т дурдсан заалтыг баримтална.

**35 дугаар зүйл**  
**Гэрээслэлийг нээх, зарлах**

1. Нутаг дэвсгэрт нь гэрээслэл байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага уг гэрээслэлийг нээх, зарлах, гэрчлэх эрх бүхий байна.

2. Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хуулийн байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний гэрээслэлийг зарласан бол гэрээслэлийг болон гэрээслэлийг зарласан тухай протоколын баталгаатай хуулбар, гэрээслэлийн байдлын тухай холбогдох материал, хэрэв шаардагдвал гэрээслэлийн эх хувийг өвлүүлэгч харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

### **36 дугаар зүйл**

#### **Нас барсан тухай мэдэгдэх**

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэн нас барвал энэ тухай зохих байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт нэн даруй мэдэгдэж, өв залгамжлагчдын тухай, тэдний байнга буюу түр оршин суугаа газар, өвлөгдөх хөрөнгийн хэмжээ, үнэ, түүнчлэн гэрээслэл байгаа эсэх талаар мэдэгдэж буй бүх зүйлийг мэдээнэ. Хэлэлцэн тохирогч нэг Талын зохих байгууллага нь Хэлэлцэн тохирогч хоёр Талын нутаг дэвсгэрийн гадна нас барсан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэн эд хөрөнгөө түүний нутаг дэвсгэрт үлдээсэн тухай мэдээ авсан тохиолдолд энэ журмыг нэгэн адил хэрэглэнэ.
2. Хэрэв нас барсан тухай мэдээг дипломат төлөөлөгчийн буюу консулын газар түрүүлж авсан бол өвлөгдөх хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах эрх бүхий байгууллагад энэ тухайгаа мэдэгдэнэ.

### **37 дугаар зүйл**

#### **Өвлөгдөх хөрөнгийг хамгаалах арга хэмжээ**

1. Нутаг дэвсгэрт нь өвлөгдөх хөрөнгө байгаа Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг нас барсны дараа уг эд хөрөнгийг хамгаалах, эрхлэн гүйцэтгэх шаардлагатай арга хэмжээг хууль тогтоомжийнхоо дагуу авна.
2. Энэ зүйлийн 1-д заасны дагуу авсан арга хэмжээнийхээ талаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт нэн даруй мэдэгдэх бөгөөд тэд шууд буюу төлөөлөгчөөрөө дамжуулан уг арга хэмжээг гүйцэтгэхэд хамтран ажиллаж болох бөгөөд мөн авсан арга хэмжээг хэрэгжүүлэхийг хүчингүй болгох, өөрчлөх, хойшлуулах санал тавьж болно. Нас барсан хүний хөдлөх өв хөрөнгө болон бичиг баримтыг дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт нь шилжүүлэн өгнө.

### **38 дугаар зүйл**

#### **Өв залгамжлах хэргийн талаар дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын эдлэх эрх хэмжээ**

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар өв залгамжлахтай холбогдсон бүх хэргийн талаар өөрийн иргэдийн эзгүй байгаа үед, эсхүл тэднээс уг хэргийг гүйцэтгэхийг итгэмжлэгдсэн өөр хүнд даалгаагүй бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын байгууллагад тусгай итгэмжлэлгүйгээр төлөөлөн оролцох эрхтэй.
2. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн нутаг дэвсгэрт нь байнга оршин суудаггүй Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрээр дамжин явах үедээ нас барсан бол түүний биедээ авч явсан эд хогшлыг ямар нэг тусгай хэрэг хөтлөхгүйгээр уг иргэн харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт шилжүүлнэ.

### **39 дүгээр зүйл**

#### **Өв хөрөнгийг шилжүүлэн өгөх**

Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт өв залгамжлалын хэргийг шийдвэрлэсний дараа хөдлөх эд хөрөнгө буюу өвлөгдөх хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг худалдаж олсон мөнгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга буюу түр оршин суугаа өв залгамжлагчид шилжүүлэх ёстой бол уг эд хөрөнгө буюу түүнийг худалдаж олсон мөнгийг Хэлэлцэн тохирогч энэ Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт дор дурдсан нөхцөлд шилжүүлнэ:

а/ өвлөгдөх эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа орны хууль тогтоомжид зааснаар эрх бүхий байгууллага өвлүүлэгчээс авлагатай этгээдийн зохих өргөдлийг нь гаргуулахаар тухайн улсад тогтоосон хугацаанд дуудсан;

б/ өвлөгдөх эд хөрөнгөнөөс авбал зохих бүх татвар, хураамжийг төлсөн буюу нэхэмжлэлийн шаардлагагыг хангасан;

в/ өвлөгдөх эд зүйлсийг гаргахыг, эсхүл тэдгээрийг худалдсаны үнийг гуйвуулахыг зохих байгууллага зөвшөөрсөн.

### **Шүүхийн зардал**

### **40 дүгээр зүйл**



## **Шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөх**

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүхийн ажиллагаанд оролцож, тэр улсын нутаг дэвсгэрт байхад нь гадаадын харьяат гэх буюу эсхүл тэд улсад оршин суудаггүй гэдэг үндэслэлээр шүүхийн зардал төлөхийг тэднээс шаардаж болохгүй.

### **41 дүгээр зүйл**

1. Хүсэлт гаргагч этгээдийн хувийн болон гэр бүлийн байдал, цалин хөлс, эд хөрөнгийн тухай бичиг баримтыг уг этгээд нутаг дэвсгэрт нь байнга буюу түр оршин суудаг Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага олгоно.
2. Хэрэв хүсэлт гаргагч этгээд Хэлэлцэн тохирогч хоёр Талын нутаг дэвсгэрт байнга буюу түр оршин суудаггүй бол тэр этгээдийн харьяалагдах улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар бичиг баримтыг олгож болно.
3. Шүүхийн зардлаас чөлөөлүүлэх тухай хүсэлтийн талаар шийдвэр гаргаж байгаа хуулийн байгууллага нь бичиг баримт олгосон байгууллагаас нэмэгдэл баримт сэлт шаардаж болно.

### **42 дугаар зүйл**

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хуулийн байгууллагад шүүхийн зардлаас чөлөөлүүлэх хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн уг хүсэлтээ байнга буюу түр оршин суугаа газрынхаа эрх бүхий байгууллагад амаар гаргаж болох бөгөөд уг байгууллага түүнийг протоколд тусгаж энэхүү Гэрээний 41 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу олгосон лавламж бичиг болон хүсэлт гаргасан этгээдээс ирүүлсэн бусад бичиг баримтын хамт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хуулийн байгууллагад хүргүүлнэ.
2. Шүүхийн зардлаас чөлөөлүүлэх хүсэлтийн хамт нэхэмжлэл гаргуулах буюу өөр бусад ажиллагаа явуулах хүсэлт тавьж болно.

## **III ХЭСЭГ**

### **Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх**

#### **43 дугаар зүйл**

##### **Эд хөрөнгийн асуудалд хамаарах шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх**

Энэхүү Гэрээний заалтын дагуу буюу мөн Гэрээнд заагаагүй тохиолдолд бол өөрийн нутаг дэвсгэрт мөрдөж байгаа журмын дагуу Хэлэлцэн тохирогч Талууд иргэний болон гэр бүлийн хэргийн талаар гаргасан хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр, түүнчлэн эд хөрөнгө эрх зүйн (хохирол нөхөн төлөх, эд зүйлийг буцаан олгох зэрэг) шаардлагатай холбогдсон эрүүгийн хэргийн талаар шүүхийн шийдвэрийг өөрийн нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрч биелүүлнэ.

#### **44 дүгээр зүйл**

##### **Эд хөрөнгийн биш асуудалд хамаарах шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх**

Хэлэлцэн тохирогч нэг Талын хуулийн болон иргэний гэр бүл, асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллагаас иргэний болон гэр бүлийн асуудлаар гаргасан эд хөрөнгийн холбогдолгүй хүчин төгөлдөр шийдвэрийг хэрэв Хэлэлцэн тохирогч нөгөө Талын байгууллагаас тухайн хэргийн талаар урьд нь гаргасан хүчин төгөлдөр шийдвэр байхгүй буюу уг асуудалд энэхүү Гэрээ ёсоор тус орны онцгой эрхэнд хамаарахгүй байвал дахин шүүхээр авч хэлэлцэхгүйгээр энэ Талын нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрнө.

#### **45 дугаар зүйл**

##### **Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх нөхцөл**

Энэхүү Гэрээний 43, 44 дүгээр зүйлд заасан шийдвэрийг дор дурдсан нөхцөлд хүлээн зөвшөөрч биелүүлнэ:

- a/ хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг нутаг дэвсгэрт нь уг шийдвэр гарсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу биелүүлэх ёстой болсон;
- b/ нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу шүүхийн шийдвэр өөрийн нь эсрэг гарсан бөгөөд шүүн таслах ажиллагаанд оролцоогүй зохигч (эсхүл түүний төлөөлөгч)-д уг хэрэг хэлэлцэх тухай зохих ёсоор цаг хугацаанд нь мэдэгдсэн, эсхүл байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхийн чадваргүй тохиолдолд зохих ёсоор төлөөлүүлсэн;

в/ нутаг дэвсгэрт нь шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлбэл зохих Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий шүүхээс тухайн хэрэг, зохигчдын талаар хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр гаргаагүй, эсхүл уг Хэлэлцэн тохирогч Талын шүүх тухайн хэргийн байцаан шийтгэх ажиллагааг үүнээс өмнө явуулж эхлээгүй;

г/ шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх нь Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн үндсэн зарчимд харшлахгүй байгаа.

#### **46 дугаар зүйл**

#### **Шийдвэрийг хүлээн зөвшөөрүүлэх буюу биелүүлэх зөвшөөрлийн тухай хүсэлт**

1. Шийдвэрийг хүлээн зөвшөөрүүлэх буюу биелүүлэх зөвшөөрлийн тухай хүсэлтийг нутаг дэвсгэрт нь уг шийдвэрийг биелүүлэх Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий шүүхэд шууд, эсхүл анхан шатны журмаар уг хэргийг хэлэлцэж шийдвэр гаргасан шүүхэд гаргаж болох бөгөөд хүсэлтийг энэхүү Гэрээний 3 дугаар зүйлд заасан журмаар гаргана.
2. Хүсэлтэд дор дурдсан зүйлийг хавсаргана:
  - а/ шүүхийн шийдвэр буюу түүний баталгаатай хуулбар, хэрэв шийдвэрт тодорхой заагаагүй бол уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бөгөөд түүнийг биелүүлбэл зохих тухай албан ёсны баримт бичиг;
  - б/ шийдвэр өөрийн нь эсрэг гарсан зохигч байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй тохиолдолд түүнд хэрэг хэлэлцэх тухай зохих ёсоор, цаг тухайд нь мэдэгдсэн, түүнчлэн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхийн чадваргүй тохиолдолд энэ Гэрээний 45 дугаар зүйлийн “б”-д заасны дагуу зохих ёсоор төлөөлүүлсэн тухай лавлагаа;
  - в/ энэхүү гэрээний 16 дугаар зүйлийн 2-т заасан журмын дагуу энэ зүйлийн “а”, “б”-д дурдсан бичиг баримтын баталгаатай орчуулга.

#### **47 дугаар зүйл**

#### **Биелүүлэх**

1. Биелүүлэх журмын нутаг дэвсгэртээ биелэлтийг хэрэгжүүлэх Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.
2. Шүүх нь шийдвэр гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн тохиолдол л хариуцагч этгээд шийдвэр биелүүлэхээс татгалзаж болно.

#### **48 дугаар зүйл**

#### **Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзах**

Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс дор дурдсан тохиолдолд татгалзаж болно:

а/ энэхүү Гэрээнд заасан журмын дагуу шүүхийн дуудлагыг цаг тухайд нь зохих ёсоор гардуулаагүйн улмаас хариуцагч буюу түүний бүрэн эрхт төлөөлөгч шүүхийн ажиллагаанд оролцож чадаагүй;

б/ шүүхийн шийдвэр нь түүнийг нутаг дэвсгэртээ хүлээн зөвшөөрч биелүүлбэл зохих Хэлэлцэн тохирогч Талын шүүхээс мөн шаардлага, үндэслэлээр өмнө нь гаргасан хуулийн хүчин төгөлдөр шийдвэртэй харшилсан;

в/ биелүүлэх шаардлагатай шүүхийн шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болоогүй.

#### **49 дүгээр зүйл**

#### **Мөнгө гуйвуулах, эд зүйлийг хилээр нэвтрүүлэх**

Энэхүү Гэрээний заалтууд нь мөнгө гуйвуулах, эд зүйлийг хилээр нэвтрүүлэн гаргахтай холбогдсон Хэлэлцэн тохирогч Талуудын хууль тогтоомжийг хөндөхгүй.

#### **IV ХЭСЭГ**

#### **Эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэх**

#### **50 дугаар зүйл**

#### **Шилжүүлэн өгөх үүрэг**

1. Хэлэлцэн тохирогч Талууд тэдний нутаг дэвсгэрт байгаа этгээдийг эрүүгийн мөрдөн байцаалт явуулах буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх зорилгоор бие биенийхээ шаардлагын дагуу харилцан шилжүүлэн өгөх үүргийг хүлээнэ.

2. Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль тогтоомжид зааснаар гагцхүү нэг жилээс дээш хугацаагаар хорих буюу түүнээс хүнд ял шийтгэл оногдуулж болох (цаашид “шилжүүлэх үр дагавар бүхий гэмт хэрэг” гэнэ) гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шилжүүлэн өгч болно.

#### **51 дүгээр зүйл**

#### **Шилжүүлэн өгөхөөс татгалзах**

Дор дурдсан тохиолдолд шилжүүлэн өгөхөөс татгалзана:

- а/ шилжүүлэн өгвөл зохих этгээд нь шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын иргэн байгаа;
- б/шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан, эсхүл хууль ёсны бусад үндэслэлийн улмаас эрүүгийн хэрэг үүсгэж буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж болохгүй болсон;
- в/ шилжүүлэн өгвөл зохих этгээдийн хувьд шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт тухайн гэмт хэргийн талаар таслан шийдвэрлэх буюу хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тогтоол гарч хуулийн хүчин төгөлдөр болсон;
- г/ эрүүгийн мөрдөн байцаалт явуулах нь шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллагын онцгой эрхэд хамаарч байгаа;
- д/ Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хууль тогтоомжоор шилжүүлэн өгөх явдлыг хүлээн зөвшөөрөөгүй;
- е/ Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хуульд зааснаар зөвхөн хохирогчийн гомдлоор үүсгэх эрүүгийн хэрэгт хохирогч зохих цагтаа гомдол гаргаагүй.

#### **52 дугаар зүйл**

#### **Эрүүгийн хэрэг үүсгэх үүрэг**

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт шилжүүлэх үр дагавар бүхий гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа өөрийн иргэний талаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын даалгавраар өөрийн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэх үүргийг Хэлэлцэн тохирогч хоёр Тал харилцан хүлээнэ.
2. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь эрүүгийн мөрдөн байцаах ажиллагааны дүнг Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв уг хэргийн талаар гаргасан таслан шийдвэрлэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон бол түүний хуулбарыг мэдэгдэлд хавсаргах ёстой.

#### **53 дугаар зүйл**

#### **Шилжүүлэн өгөх тухай шаардлага**

1. Шаардлагад дор дурдсан бичиг баримтыг хавсаргана:
  - а/ гэмт хэргийн бүрэлдэхүүн, гэмт хэрэг үйлдсэн газар, цаг болон гэмт хэргийн зүйлчлэлийг заасан хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх буюу цагдан хорих тухай тогтоолын баталгаатай хуулбар, хэрэв гэмт хэргийн улмаас хохирол учирсан бол түүний хэмжээг заана;
  - б/шаардлага тавьж байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрүүгийн хуулийн тухайн гэмт хэргийн зүйлчлэн ангилж байгаа заалт;
  - в/ ял шийтгэлийнхээ зохих хэсгийг эдэлсэн ялтныг шилжүүлэх тухай шаардлага тавьсан тохиолдолд ялын эдлээгүй үлдсэн хугацааны тухай;
  - г/шилжүүлэн өгөх шаардлагатай этгээдийн харьяалал, түүний оршин суугаа газар, хувийн байдлын тухай мэдээ сэлт, бичиг баримт түүнчлэн бололцооны хэрээр гаднах байдлын тухай тодорхойлолт, гэрэл зураг, хурууны хээ.

#### **54 дүгээр зүйл**

#### **Шилжүүлж өгөх тухай шаардлагын нэмэлт мэдээ сэлт**

1. Хэрэв шилжүүлэн өгөх тухай шаардлагад хэрэгцээтэй бүх мэдээ сэлт бүрдэл болоогүй байвал шаардлага хүлээж авсан Хэлэлцэн тохирогч Тал шаардлага тавьсан Хэлэлцэн тохирогч Талаас нэмэлт мэдээ сэлт хүсэж, түүнийг ирүүлбэл зохих хугацааг тодорхойлно.
2. Хэрэв өмнөх заалтад дурдсанаар тогтоосон буюу сунгасан хугацаанд шаардлагатай мэдээ сэлтийг аваагүй бол шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага шилжүүлэн өгөх ажиллагааг зогсоож, цагдан хоригдсон этгээдийг суллаж болно.

#### **55 дугаар зүйл**

#### **Шилжүүлэн өгөх этгээдийг цагдан хорих**

Шилжүүлэн өгөх тухай шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал энэхүү гэрээнд заасан шилжүүлэн өгч болохгүйгээс бусад тохиолдолд шилжүүлэн өгвөл зохих этгээлийг нэн даруй цагдан хорих арга хэмжээ авна.

**56 дугаар зүйл**  
**Шилжүүлэн өгөх тухай шаардлагыг авахын**  
**өмнө цагдан хорих**

1. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал шилжүүлэн өгвөл зохих этгээдийг цагдан хорих тухай тогтоол нэгэнт гарсан, эсхүл хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол буюу өөр магадлал байгааг иш үндэс болгон зааж уг этгээдийг цагдан хорих тухай хүсэлт гаргахын зэрэгцээ энэ Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн авах тухай шаардлага явуулахдаа мэдэгдсэн бол шилжүүлбэл зохих этгээдийг шилжүүлэн авах тухай шаардлага ирэхээс өмнө цагдан хорьж болно. Ийм хүсэлтийг шуудан, телефон, цахилгаанаар буюу радиогоор болон бусад замаар тавьж болно.
2. Хэрэв шилжүүлэн өгөх үр дагавар бүхий гэмт хэргийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт үйлдсэн тухай мэдээ байвал дээрх шаардлага ирээгүй байсан ч Хэлэлцэн тохирогч нэг Талын зохих хуулийн байгууллага өөрийн нутаг дэвсгэрт байгаа этгээдийг цагдан хорьж болно.
3. Энэ зүйлийн 1, 2-т заасан цагдан хорих цаг хугацааны талаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талд нэн даруй мэдэгдэнэ.
4. Цагдан хорих тухай мэдэгдэл явуулсан өдрөөс хойш 2 сарын дотор шилжүүлэн өгөх шаардлага Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас ирэхгүй бол энэ зүйлд заасны дагуу цагдан хорьсон этгээдийг суллаж болно. Дээрх шалтгаанаар сулласан тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талд мэдэгдэнэ.

**57 дугаар зүйл**  
**Шилжүүлэн өгөхийг хойшлуулах**

Шилжүүлэн өгвөл зохих этгээд шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдсан буюу өөр хэргийн учир ял шийтгүүлсэн бол эрүүгийн мөрдөн байцаалт явуулж дуусгах буюу таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх, эсхүл хугацаанаас өмнө суллах хүртэл түүнийг шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.

**58 дугаар зүйл**  
**Түр шилжүүлэн өгөх**

1. Хэрэв энэхүү Гэрээний 57 дугаар зүйлд зааснаар шилжүүлэн өгөхийг хойшлуулахад эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрөх буюу гэмт хэргийг мөрдөх явцад ноцтой бэрхшээл учруулахаар байвал шилжүүлэн өгч болно.
2. Түр шилжүүлэн өгсөн этгээдийг түүнд холбогдох эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дуусмагц буцаана.

**59 дүгээр зүйл**  
**Шилжүүлэн өгөх тухай хэд хэдэн улсын шаардлага**

Хэрэв нэг этгээдийг шилжүүлэн өгөх тухай шаардлага хэд хэдэн улсаас ирвэл шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгөх этгээдийн харьяалал, түүнчлэн хэргийн хүнд, хөнгөний байдал, гэмт хэрэг үйлдсэн газрыг харгалзан аль шаардлагыг хангавал зохихыг шийдвэрлэнэ.

**60 дугаар зүйл**  
**Шилжүүлэн өгөх**

1. Шилжүүлэн өгөх шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгөх газар, цаг хугацааг шаардлага тавьж байгаа Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ.
2. Хэрэв шаардлага тавьсан Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгөхөөр болзсон өдрөөс хойш 15 хоногийн хугацаанд шилжүүлэн өгөх этгээдийг хүлээн авахгүй бол уг этгээдийг суллаж болно. Хугацааг 15 хоногоос хэтрүүлэхгүйгээр сунгаж болно.

**61 дүгээр зүйл**  
**Дахин шилжүүлэн өгөх**

Хэрэв шилжүүлэн өгсөн этгээд эрүүгийн мөрдөн байцаалтаас болон таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх явдлаас зайлсхийж, шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт буцаж ирвэл шаардлага тавьж байгаа Талын шинэ шаардлагын дагуу энэхүү Гэрээний 53-р зүйлд дурдсан материалгүйгээр уг этгээдийг дахин шилжүүлнэ.

**62 дугаар зүйл**  
**Эд зүйлийг шилжүүлэх**

1. Шилжүүлэн өгөх үр дагавар бүхий гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэрэг үйлдэж олсон эд зүйл, мөн түүнчлэн эрүүгийн хэрэгт нотлох баримт болгон ашиглаж болох бусад эд зүйлд буюу тэдгээрийн үнийг уг гэм этгээд нас барсан буюу бусад шалтгаанаар түүнийг шилжүүлэн өгөх бололцоогүй болсон тохиолдолд ч шаардлага тавьж байгаа Хэлэлцэн тохирогч Талд шилжүүлэн өгнө.
2. Хэрэв эдгээр эд зүйл нь шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч талд эрүүгийн өөр хэрэг шийдвэрлэхэд ач холбогдолтой байвал тэдгээрийг шилжүүлэн өгөхийг түр хойшлуулж болно.
3. Шаардлага тавьсан Хэлэлцэн тохирогч Талд шилжүүлэн өгсөн эд зүйлийн талаар гуравдахь этгээдийн эдлэх эрх халдашгүй хэвээр байна. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дууссаны дараа Хэлэлцэн тохирогч Талууд эдгээр эд зүйлийг авах эрх бүхий өөрийн нутаг дэвсгэрт байгаа этгээдэд шилжүүлэн өгнө. Хэрэв уг эд зүйлийн талаар эрх эдлэх этгээд шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт байвал шаардлага тавьсан Хэлэлцэн тохирогч Тал тухайн эд зүйлийг дээр дурдсан хүмүүст шилжүүлэн өгүүлэхээр түүнд явуулна.

**63 дугаар зүйл**  
**Шилжүүлэн өгсөн этгээдийг мөрдөх хязгаар**

1. Шилжүүлэн өгсөн этгээдийг шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн өгөхөөс өмнө үйлдсэн бөгөөд шилжүүлэн өгөх тухай шаардлагад дурдаагүй өөр хэргийн учир эрүүгийн хариуцлагад татаж, ял шийтгэж болохгүй.
2. Шилжүүлэн өгсөн этгээдийг шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрөлгүйгээр гуравдахь улсад шилжүүлэн өгч болохгүй.
3. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрөл шаардахгүй тохиолдол:  
а/шилжүүлэн өгсөн этгээд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж дууссан буюу ял эдэлж дууссан, эсхүл хугацаанаас өмнө суллагдсан өдрөөс хойш нэг сарын дотор боломж байсаар атал түүнийг шилжүүлэн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс гарч яваагүй. Харин уг этгээд шаардлага тавьсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс өөрийн буруу биш шалтгаанаар явж чадаагүй байсан хугацааг дээр дурдсан хугацаанд оруулан тоолохгүй  
б/шилжүүлэн өгсөн этгээд шаардлага тавьсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс явсныхаа дараа сайн дураараа эргэж ирсэн.

**64 дүгээр зүйл**  
**Дамжуулан өнгөрүүлэх**

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хүсэлтээр гуравдахь улсаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талд шилжүүлэн өгөх этгээдийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг зөвшөөрнө. Хэрэв энэ Гэрээнд зааснаар шилжүүлэн өгч болохгүй байвал Хэлэлцэн тохирогч Талууд дамжуулан өнгөрүүлэх үүрэг хүлээхгүй.
2. Дамжуулан өнгөрүүлэх тухай шаардлагыг шилжүүлэн өгөх шаардлагын адил журмаар үйлдэн явуулна.

**65 дугаар зүйл**  
**Шилжүүлэн өгөх, дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдсон зардал**

Шилжүүлэн өгөхтэй холбогдсон зардлыг уг зардал нутаг дэвсгэрт нь гарсан Хэлэлцэн тохирогч Тал хариуцна. Харин дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдсон зардлыг шаардлага тавьж байгаа Хэлэлцэн тохирогч Тал хариуцна.

**66 дугаар зүйл**  
**Таслан шийдвэрлэх тогтоол, мөрдөн байцаалтын тухай мэдээлэл**

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн хуулийн байгууллагаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдийн эсрэг гаргасан хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоолд хамаарах мэдээ сэлтийг шилжүүлэн өгнө.
2. Нутаг дэвсгэртээ урьдчилан мөрдөн байцаалтад буюу шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдийн тухай мэдээ сэлтийг Хэлэлцэн тохирогч Талууд нэг нэгэндээ шилжүүлэн өгнө.
3. Мэдээлэлд гэмт хэрэг болон хүлээлгэсэн хариуцлагын тухай зайлшгүй мэдээ сэлтийг тусгасан байх ёстой бөгөөд түүнийг дипломат шугамаар хүргүүлнэ.

**67 дугаар зүйл**  
**Эрүүгийн мөрдөн байцаалтын дүнгийн тухай мэдэгдэх**

Хэлэлцэн тохирогч Талууд шилжүүлэн өгсөн этгээдийн талаар явуулсан эрүүгийн мөрдөн байцаалтын дүнгийн тухай нэг нэгэндээ мэдэгдэж байна. Хэрэв шилжүүлэн өгсөн этгээдийн эсрэг таслан шийдвэрлэх тогтоол гарсан бол уг тогтоол хүчин төгөлдөр болсны дараа түүний баталгаатай хуулбарыг хүргүүлнэ.

**68 дугаар зүйл**  
**Ял шийтгэсэн байдлын тухай мэдээлэл**

Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт өмнө нь амьдарч байсан бөгөөд шаардлага өгөгч Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдаж байгаа этгээдийн ял шийтгэгдсэн байдлын талаархи мэдээллийг Хэлэлцэн тохирогч Талууд бие биенийхээ хүсэлтээр болгож байна.

**69 дүгээр зүйл**  
**Ял шийтгэгдсэн этгээдийг шилжүүлэх**

Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт хорих ял шийтгэгдсэн этгээдийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт таслан шийдвэрлэх тогтоолыг гүйцэтгэхээр шилжүүлэх асуудлыг Берлин хотноо 1978 оны 5 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан “Хорих ял шийтгэгдсэн хүнийг харьяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэх тухай” Конвенцийн заалтын дагуу гүйцэтгэнэ.

**V ХЭСЭГ**  
**Төгсгөлийн заалт**

**70 дугаар зүйл**

1. Энэхүү Гэрээг соёрхон батлана.
2. Батламж жуух бичгийг Гавана хотод солилцоно.

**71 дүгээр зүйл**

Энэхүү Гэрээ батламж жуух бичгүүдийг солилцсон өдрөөс гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болж, хугацаагүйгээр үйлчилнэ. Гэхдээ Хэлэлцэн тохирогч аль ч Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талд гэрээг цуцлах тухайгаа албан ёсоор мэдэгдэх замаар түүнийг цуцалж болно. Ийм тохиолдолд цуцлах тухай бичгээ аль нэг Талд мэдэгдсэн өдрөөс эхлэн арван хоёр сарын хугацаа өнгөрсний дараа Гэрээ хүчингүй болно.

Энэхүү Гэрээг монгол, испани, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд гурван эх нь адил хүчинтэй байна. Энэхүү Гэрээний заалтыг монгол, испани хэлээр тайлбарлах үед зөрүү гарвал орос эхийг баримтална.

Хэлэлцэн тохирогч хоёр Талын бүрэн эрхт төлөөлөгчид харилцан тохиролцсоноо нотлон энэхүү Гэрээнд гарын үсэг зурж, тамга дарав.

Улаанбаатар хотноо 1989 оны 8 сарын 16-нд үйлдэв.